



АУДИТЫН ТАЙЛАН

“ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2023 ОНЫ НЭГТГЭСЭН ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛ”-Д ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

Аудитын код: ДУА-2024/1/НА-СТА-ТЕЗ



Цахим хуудас: www.audit.mn
Дундговь аймаг
2024 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Ихбаяр
Утас: 70593113
Цахим хаяг: ikhbayard@audit.gov.mn

Аудитор: Ж.Угтахбаяр
Аудитор: Д.Должинсүрэн
Утас: 70593113
Цахим хаяг: Ugtakhbayarj@audit.gov.mn
Doljinsurend@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

.....	0
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	2
ЗУРАГЛАЛ, ГРАФИК, ХҮСНЭГТИЙН ТОВЬЁГ	2
.....	3
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛАХ ТУШААЛ.....	3
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	4
ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ.....	5
1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫГ ТОДОТГОЛООР 56,897.8 САЯ ТӨГРӨГ БОЛГОН БАТАЛСНААС, ГҮЙЦЭТГЭЛЭЭР 62,545.7 САЯ ТӨГРӨГ ТӨВЛӨРЧ, 9.9 ХУВИАР ДАВСАН НЬ ТАТВАРЫН БОЛОН ТАТВАРЫН БУС ОРЛОГО НИЙТ ДҮНГЭЭР 137.8 ХУВИАР ДАВЖ БИЕЛСЭНТЭЙ ХОЛБООТОЙ БАЙНА.	6
1.1 Тайлант оны төсвийн орлогыг тодотгол хийх нөхцөл байдал үүссэний улмаас 10,440.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 56,897.8 сая төгрөг болгон баталсан байна.	6
1.2 Татварын болон татварын бус орлого нийт дүнгээр 37.8 хувиар давсан боловч хүүгийн орлого 2,432.4 сая төгрөгөөр тасарсан нь Сангийн яамнаас өндрөөр төлөвлөж өгсөнтэй холбоотой байна.....	7
2. ТӨСВИЙН НИЙТ ЗАРДЛЫГ ТӨЛӨВЛӨЖ, ЗАРЦУУЛАХДАА САНГИЙН ЯАМНААС ӨГСӨН ЧИГЛЭЛ, ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ЗАРИМ САНАЛ, ДҮГНЭЛТИЙГ ХАРГАЛЗАН ҮЗДЭГГҮЙ, ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬ, ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙТЭЙ ХОЛБООТОЙ БАЙНА.....	11
2.1 Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн төслийг боловсруулж, батлахдаа Сангийн яамнаас өгсөн чиглэл, Төрийн аудитын байгууллагын санал, дүгнэлтийг бүрэн авч үзэхгүй байна.....	11
2.2 Төсвийн зарцуулалттай холбоотой нийт 470.7 сая төгрөгийн зөрчил илэрсний 34.1 хувь нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил байна.....	12
2.3 Төсвийн тухай хуулийн дагуу ОНХС-ийн дансанд төвлөрүүлэх 281.4 сая төгрөгийн хандив, тусламжийг аймаг, сумдын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, урсгал зардалд зарцуулсан байна.....	16
3. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙЖ, ӨМНӨХ АУДИТЫН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЛТТАЙ ГЭЖ ҮЗСЭН БАЙНА.....	17
3.1 Хяналт, шинжилгээ, үнэлгээгээр Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 94.6 хувьтай байна.....	17
3.2 Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийн дагуу аймгийн Засаг дарга, Татварын хэлтсээс авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд тодорхой үр дүнд хүрсэн байна.	18
Дүгнэлт.....	19
Зөвлөмж.....	20
Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал.....	20
Хавсралтууд.....	22

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан

ЗУРАГЛАЛ, ГРАФИК, ХҮСНЭГТИЙН ТОВЬЁГ

Зураглалын товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураглал 1	Төсвийн гүйцэтгэлийн үйл явцын зураглал	4

Графикийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	Татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /Сумдаар/	8
График 2	ААНОАТ-ын төлөвлөгөө, гүйцэтгэл	9
График 3	Түгээмэл тархацтай ашигт малтмал	9
График 4	Малын тоо толгойн албан татвар	11
График 5	Төсвийн зардлын гүйцэтгэлийн төсөл	11
График 6	Нэмэлтийн дансны орлогын задаргаа	15
График 7	Нэмэлтийн дансны зарлагын задаргаа/ хувиар/	16
График 8	Төрийн хэмнэлтийн хуулийн холбогдолтой зөрчил	16

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Төсвийн орлогын төлөвлөгөөний задаргаа	5
Хүснэгт 2	Төсвийн зардлын батлагдсан төсөв, гүйцэтгэл	5
Хүснэгт 3	Сангийн яамд хүргүүлсэн болон хянуулсан төсвийн орлого	5
Хүснэгт 4	Төсвийн орлогын 2023 оны батлагдсан, тодотгосон төсөв	6
Хүснэгт 5	Татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	6
Хүснэгт 6	Татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	8
Хүснэгт 7	Төсвийн зардлын анх батлагдсан төсөв, тодотгосон төсөв	12
Хүснэгт 8	Санхүүгийн аудитаар зардалтай холбоотой зөрчлийн ангилал	13
Хүснэгт 9	Аймаг, сумын ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэл	13
Хүснэгт 10	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ТАХ-ний гүйцэтгэл	14
Хүснэгт 11	ХХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэл, зөрүү, биелэх боломж	14
Хүснэгт 12	Нэмэлт санхүүжилтийн орлогыг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулсан	15
Хүснэгт 13	Яамдтай байгуулсан гэрээний гүйцэтгэлийг үнэлсэн үнэлгээ	16
Хүснэгт 14	Өмнөх аудитаар өгөгдсөн зөрчлийн харьцуулалт	18



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1/09

Мандалговь

Аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.2 Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх үүрэг”-ийн 1.1, 1.3, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 18 дугаар зүйлийн 9-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл тайлан”-д хийсэн гүйцэтгэлийн тайланг /ДУА-2024/1/СТА-ТЕЗ/-г баталсугай.

2. Аудитаар илэрсэн зөрчил, зөвлөмжийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3. “Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл тайлан”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг Үндэсний аудитын газар болон аймгийн Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.

4. Нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудитаар илэрсэн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан үр дүнгийн талаар 2024 оны 11 сарын 25-ны өдрийн дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг аймгийн Засаг дарга /Ц.Мөнхбат/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Г.Энхтайван/, ерөнхий санхүүч /С.Адьяасүрэн/-д тус тус зөвлөсүгэй.

5. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2024 оны 4 дүгээр улиралд гарган танилцуулахыг Санхүүгийн аудитын албаны ахлах аудитор /Д.Ихбаяр/, аудитор /Ж.Угтахбаяр/, /Д.Должинсүрэн/ нарт үүрэг болгосугай.



Р.МӨНХТОГТОХ

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/04 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын 2024 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”, Дундговь аймгийн Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэлээ.
Аудитын зорилт:	Дундговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн хэрэгжилтийг шалган, дүгнэлт гарган холбогдох албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд: ➤ Орон нутгийн төсвийн орлогыг бодитой төлөвлөж, бүрэн төвлөрүүлсэн эсэх; ➤ Орон нутгийн төсвийн зарлагыг бодитой төлөвлөж, хууль, журмын дагуу зарцуулсан эсэх; ➤ Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн зорилтот түвшинд хүрсэн эсэх.
Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:	Аудитад асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүйтэй холбоотой дараах стандарт, хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. ❖ АДБОУС ❖ Төрийн аудитын стандарт MNS 6817-7:2020 ❖ Монгол Улсын Үндсэн хууль; ❖ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль; ❖ Төсвийн тухай хууль; ❖ Төрийн аудитын тухай хууль; ❖ Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль; ❖ Татварын багц хуулиуд; ❖ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль; ❖ Бусад холбогдох хууль, тогтоомж, журам, зааврууд.
Аудитын хамарсан хүрээ:	Аудитыг “Дундговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан, 15 сумын төсвийн гүйцэтгэлийн тайлан, татварын мэдээ, хяналт шинжилгээ үнэлгээний тайлан, аймгийн болон сумдын орон нутгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн санг хамруулан, Аудитын олон улсын стандарт, гарын авлага, арга зүй, холбогдох бусад эрх зүйн актуудад тулгуурлан аудитыг гүйцэтгэсэн.
Аудитын арга зүй:	Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам (2020 он), Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал (2021 он)-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулсан.

Аудит хийх багийн
бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитын дүн


Аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлэн, ахлах аудитор Д.Ихбаяр, аудитор Ж.Угтахбаяр, Д.Должинсүрэн нар 2024 оны 04 дүгээр сарын 05-ний өдрөөс 2024 оны 04 дүгээр сарын 19-ны өдрийг дуустал хугацаанд аудитыг гүйцэтгэлээ.

Аудитаар төсвийн гүйцэтгэлийн орлоготой холбоотой 2, зардалтай холбоотой 3 асуудлыг шийдвэрлэх 5 заалт бүхий зөвлөмж, УАГ-т төсвийн орлогын төлөвлөлттэй холбоотой саналыг хүргүүлсэн.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газраас ирүүлсэн Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2023 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамжийн хүрээнд 2023 оны орон нутгийн нийт төсвийн төслийг 36,174.5 сая төгрөгөөр боловсруулж, “FISCAL-B” программд оруулан, Төсвийн тухай хуулийн 8 дугаар бүлгийн 8.4.3¹-д заасны дагуу Сангийн яаманд хүргүүлсэн байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг Сангийн яам 33.6 хувь буюу 12,172.7 сая төгрөгөөр бууруулж, 24,001.8 сая төгрөгөөр хянажээ.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаар Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг баталж, 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр Дундговь аймагт олгох санхүүгийн дэмжлэгийг 16,965.5 сая төгрөг, ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 11,875.4 сая төгрөгөөр тус тус баталсан байна.



¹/Төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн саналаа жил бүрийн 07 дугаар сарын 25-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн аудитын байгууллага, Улсын Их Хуралд хүргүүлж, нийтэд ил тод мэдээлэх/

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль болон аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамжаар орон нутгийн төсвийн нийт орлогыг 56,897.8 сая төгрөгөөр баталжээ. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №1 Төсвийн орлогын төлөвлөгөөний задаргаа /сая.төг/

Орлогын эх үүсвэр	2022 оны төлөвлөгөө		Нийт	2023 оны төлөвлөгөө		Нийт	Зөрүү
	Аймаг	Сум		Аймаг	Сум		
1 Санхүүгийн дэмжлэг	11,936.1		11,936.1	16,965.5		16,965.5	5,029.4
2 ОНХС	7,875.3		7,875.3	11,875.4		11,875.4	4,000.1
3 Татварын орлого	1,226.0	8,307.0	9,533.0	4,476.7	11,089.7	15,566.4	6,033.4
4 Урьд оны үлдэгдэл	1,782.5	5,096.5	6,879.0	1,534.25	5,445.3	6,979.6	100.6
5 ОНЕО үлдэгдлээс	1,403.0	1,292.7	2,695.7	1,164.8	1,192.5	2,357.3	(338.5)
6 Төвлөрүүлэх орлого	287.3	1,658.4	1,945.7	1,087.3	2,066.4	3,153.7	1,208.0
Дүн	24,510.2	16,354.6	40,864.9	37,103.9	19,793.9	56,897.8	16,033.0

Өмнөх онтой харьцуулахад санхүүгийн дэмжлэг 5,029.4 сая, ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 4,000.1 сая төгрөгөөр өссөн байна. Төсвийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх² хэсэгт заасны дагуу аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд төсвийн төслийг өргөн мэдүүлж, орон нутгийн төсвийн орлогыг батлуулжээ.

Дундговь аймгийн 2023 оны төсвийн зарлагыг 56,897.8 сая төгрөгөөр төлөвлөснөөс 82.0 хувь буюу 46,677.2 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт №2 Төсвийн зардлын батлагдсан төсөв, гүйцэтгэл /сая.төг/

Үзүүлэлт	Нэгтгэл		Зөрүү	Хувь
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Урсгал зардал	30,749.5	28,487.9	2,261.6	92.6
Хөрөнгийн зардал	23,355.8	16,784.4	6,571.4	71.9
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан зээл	2,792.5	1,404.9	1,387.6	50.3
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	56,897.8	46,677.2	10,220.6	82.0

1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫГ ТОДОТГОЛООР 56,897.8 САЯ ТӨГРӨГ БОЛГОН БАТАЛСНААС, ГҮЙЦЭТГЭЛЭЭР 62,545.7 САЯ ТӨГРӨГ ТӨВЛӨРЧ, 9.9 ХУВИАР ДАВСАН НЬ ТАТВАРЫН БОЛОН ТАТВАРЫН БУС ОРЛОГО НИЙТ ДҮНГЭЭР 137.8 ХУВИАР ДАВЖ БИЕЛСЭНТЭЙ ХОЛБООТОЙ БАЙНА.

1.1 Тайлант оны төсвийн орлогыг тодотгол хийх нөхцөл байдал үүссэний улмаас 10,440.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 56,897.8 сая төгрөг болгон баталсан байна.

Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасны дагуу аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч 2023 оны төсвийн төслийг удирдамжид заасан зарчмын хүрээнд орон нутгийн төсвийн суурь орлогыг 18 нэр төрлөөр нийт 7,338.1 сая төгрөгөөр боловсруулж, тус хуулийн 8.4.3³-д заасны дагуу Сангийн яаманд хүргүүлжээ. Сангийн яам 2023 оны төсвийн жилийн суурь орлогыг 1,221.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 8,559.5 сая төгрөг болгон хянасан байна.

ТЕЗ-аас хүргүүлсэн орлогын төсвийн төслийг Сангийн яамны хянасан дүн болон батлагдсан төсөвтэй зэрэгцүүлэн харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №3 Сангийн яаманд хүргүүлсэн болон хянуулсан төсвийн орлого /сая.төг/

Орлогын төрөл	Сангийн яаманд хүргүүлсэн санал	Сангийн яамны хянасан	Батлагдсан	/Нэмэгдсэн +, хасагдсан -/
Татварын орлого	5,644.6	7,079.5	11,343.0	4,263.5
Татварын бус орлого	1,693.5	1,480.0	4,170.4	2,690.4
Хөрөнгийн орлого	-	-	53.0	53.0
Нийт дүн	7,338.1	8,559.5	15,566.4	7,006.9

² Төсвийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 /Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн төсвийн төслийг боловсруулж, энэ хуулийн 67.2-т заасан танилцуулгын хамт тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ/

³ “Төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн саналаа жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх”

Сангийн яам Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүргүүлсэн саналаас материаллаг дүнтэй цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг 676.4 сая, аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 375.0 сая, үйл ажиллагааны орлогыг 120.0 сая, Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогыг 87.0 сая төгрөгөөр тус тус нэмж хянасан байна.

Аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны төсөв батлах тухай тогтоолоор төсвийн эх үүсвэрийг 46,457.6 сая төгрөгөөр баталсныг 2023 оны 06 дугаар сард 56,897.8 сая төгрөг болгон 10,440.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосон байна.

Хүснэгт №4 Төсвийн орлогын 2023 оны батлагдсан, тодотгосон төсөв

/сая.төг/

Эх үүсвэр		2022 оны төлөвлөг өө	2023 он		
			төлөвлөгө ө	тодотгосо н	зөрүү
А		1	2	3	4=3-2
Улсын төсвөөс	ОНХС	7,875.3	9,816.0	11,875.4	2,059.4
	Санхүүгийн дэмжлэг	11,936.1	14,132.3	16,965.5	2,833.2
Орон нутгийн төсвөөс	Татварын болон татварын бус орлого	1,226.0	12,192.4	15,566.4	3,374.0
	ОНЕО-ын үлдэгдэл	1,403.0	1,210.8	2,357.3	1,146.5
	Төвлөрүүлэх орлого	2,608.4	2,148.9	3,153.7	1,004.8
	Урьд оны үлдэгдэл	1,783.5	6,957.2	6,979.6	22.4
дүн		26,832.3	46,457.6	56,897.8	10,440.2

Төрийн албан хаагчийн цалин, хөлсийг 2023 оны 07 сараас нэмэгдүүлэх болсонтой холбоотой улсын төсвөөс санхүүжих орлогыг 4,892.6 сая төгрөгөөр, орон нутгийн төсвөөс санхүүжих орлогын төлөвлөгөөг 5,547.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж баталсан байна. Сангийн яам төсвийн орлогыг 8,559.5 сая төгрөгөөр хянасныг аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар 7,006.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталжээ.



1.2 Татварын болон татварын бус орлого нийт дүнгээр 37.8 хувиар давсан боловч хүүгийн орлого 2,432.4 сая төгрөгөөр тасарсан нь Сангийн яамнаас өндрөөр төлөвлөж өгсөнтэй холбоотой байна.

Аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор нийт урсгал орлогыг 15,566.4 сая төгрөгөөр төвлөрүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 21,453.0 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, 37.8 хувь буюу 5,886.6 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт №5 Татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая.төг/

Татварын орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
А	1	2	3=2-1
Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлого	6,249.0	7,164.5	915.5
Хөрөнгө борлуулсны 2 хувь	120.0	161.0	41.0
Үйл ажиллагааны орлого	450.0	304.0	(146.0)
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт (-тэмдэгтэй)	(406.7)	(406.7)	(0.0)
ААН-ын орлогын албан татвар	450.0	7,428.0	6,978.0
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	151.1	179.0	28.0
Бууны албан татвар	18.5	18.3	(0.2)
Малд ноогдох албан татвар	1,563.6	1,157.0	(406.6)
Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	320.0	348.3	28.3
Улсын тэмдэгтийн хураамж	160.0	142.8	(17.2)
Газрын төлбөр	556.8	1,303.6	746.8
Дуудлага худалдаа сонгон шалгаруулалт	155.0	289.0	134.0
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	380.0	237.6	(142.4)
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	761.5	661.6	(99.9)
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	108.5	16.5	(92.0)
Бусад татвар, хураамж нохойны	61.8	59.7	(2.1)
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	243.9	159.1	(84.8)
Татварын орлогын дүн	11,343.0	19,223.3	7,880.3

Татварын орлогын төлөвлөгөө нийт 7,880.3 сая төгрөгөөр давж биелснээс материаллаг хэмжээгээр давж биелсэн дараах 5 нэр төрлийн орлого байна. Үүнд:

- **Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого** төлөвлөгөөнөөс 915.5 сая төгрөгөөр давж биелжээ. Тус орлогыг 6,249.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 7,164.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн нь Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 07 дугаар сард төрийн байгууллагын зарим албан хаагчдын албан тушаалын цалингийн доод хэмжээг шинэчлэн баталсантай холбоотой байна.
- **Хөрөнгө борлуулсны орлогын татвар** төлөвлөгөөнөөс 41.0 сая төгрөгөөр давж биелжээ. Тус орлогыг 120.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 161.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн нь аймгийн хэмжээнд шинээр барилга, байгууламж нэмэгдэж иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын худалдан авалт өссөнтэй холбоотой байна.
- **ААНБ-ын орлогын албан татвар** төлөвлөгөөнөөс 6,978.0 сая төгрөгөөр давж биелжээ. Тус орлогыг 450.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 7,428.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн нь Сангийн сайдын 2022 оны А/7 дугаар тушаалд өөрчлөлт орж батлагдсан төлөвлөгөөнөөс давсан орлогыг орон нутагт /байрилаар/хуваарилсантай холбоотой байна.
- **Газрын төлбөрийн орлого** төлөвлөгөөнөөс 746.8 сая төгрөгөөр давж биелсэн. Тайлант онд 556.8 сая төгрөгийн орлогын төлөвлөгөөтэй, гүйцэтгэлээр 1,303.6 сая төгрөгийг төвлөрүүлжээ. Орлогын төлөвлөгөө давж биелсэн нь өмнөх оны өр төлөгдсөн, мэдээллийн санд нөхөн бүрдүүлэлт хийж, газар ашиглах талбай өссөн, газрын төлбөрийг и-монголиа, и-баримт зэрэг аппликейшнээр төлдөг болсонтой холбоотой байна.
- **Дуудлага худалдаа сонгон шалгаруулалтын орлого** төлөвлөгөөнөөс 134.0 сая төгрөгөөр давж биелсэн.

Тус орлогыг 155.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 289.0 сая төгрөгийг төвлөрүүлжээ. Орлогын төлөвлөгөө давж биелсэн нь Сайнцагаан, Дэлгэрцогт, Луус, Гурвансайхан, Адаацаг, Дэрэн сумдад салхин сэнсний газар олгох дуудлага худалдаа хийсэнтэй холбоотой байна.


Дараах 5 нэр төрлийн орлого материаллаг дүнгээр тасарсан байна.

- **Үйл ажиллагааны орлогын** төлөвлөгөө 146.0 сая төгрөгөөр тасарсан нь Говь-Угтаал, Дэрэн, Цагаандэлгэр, Хулд, Луус сумд орлогыг 70.9-83.0 хувиар тасалсан нь орлогын төлөвлөгөө тасрахад голлон нөлөөлжээ. Орлого буурсан шалтгаан нь арьс шир, ноосны урамшууллыг огт олгоогүйтэй холбоотой байна.
- **Малын тоо толгойн албан татвар** нийт дүнгээрээ 406.6 сая төгрөгөөр тасарсан байна. Адаацаг, Хулд, Луус сумд 104-138 хувиар давуулан биелүүлсэн бол Өндөршил, Дэлгэрхангай, Сайхан-Овоо сумд 34.2-59.1 хувиар тус тус тасарсан байна. Бүх сумдад зохион байгуулсан малчдын өдөрлөгүүдээр малын тоо толгойн албан татвар төлөх талаар мэдээллийг газар дээр нь өгч, татварын нэхэмжлэлийг тухай бүр үүсгэсэн ч өвөлжилт хүндэрсэнтэй холбоотойгоор малчид татвараа бүрэн төвлөрүүлээгүй байна.
- **Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого** 142.4 сая төгрөгөөр тасарчээ. Энэ нь Эрдэнэдалай, Сайхан-Овоо, Өлзийт, Гурвансайхан, Өндөршил, Баянжаргалан сумдад нийт 331.0 сая төгрөгийн төлөвлөгөө батлагдсан ч огт биелээгүй. Харин Адаацаг, Хулд, Цагаандэлгэр сумдад төлөвлөгөө батлагдаагүй ч гүйцэтгэлээр 153.7 сая төгрөг орсон байна. Орлогын төлөвлөгөө тасарсан нь тус онд Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас тусгай зориулалтын ангийн зөвшөөрөл олгоогүйтэй холбоотой байна.
- **Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого** 99.9 сая төгрөгөөр тасарсан нь “Эрдэнэс Силвер Ресурс” ХХК-тай ус ашиглах гэрээ байгуулсан ч үйлдвэр бүрэн хүчин чадлаар ажиллаагүй, гүйцэтгэлээр усны төлбөрийг шилжүүлсэнтэй холбоотой байна.
- **Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлого** төлөвлөгөөнөөс 92.0 сая төгрөгөөр тасарсан байна. Цагаандэлгэр, Өлзийт, Луус, Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Сайнцагаан сумдад 72.5 сая төгрөгийн төлөвлөгөө батлагдсан ч огт биелээгүй байна. Аймгийн хэмжээнд Баянжаргалан суманд ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 1 компани байгаа ч үйл ажиллагаа явуулаагүйгээс орлого тасарсан байна.

Орлогын төлөвлөгөөг 10 сум 2.8-131.7 хувиар давуулан биелүүлж, 6 сум 0.2-27.7 хувиар тасалсан байна.

Үүнийг сум тус бүрээр графикаар харуулбал:

График №1 Татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая.төг/



Орлогын төлөвлөгөөг Дэлгэрцогт, Баянжаргалан, Гурвансайхан, Сайнцагаан, Адаацаг сумд болон аймгийн төв давуулан биелүүлсэн байна. Шалтгааныг тодруулахад төлөвлөгөө батлаагүй ан амьтны нөөц ашигласны төлбөр орсон, газрын төлбөрийн өмнөх оны өр төлөгдсөн, газрын мэдээллийн санд нөхөн бүрдүүлэлт хийснээр газар ашиглах талбай өссөн, төрийн байгууллагын зарим албан хаагчдын албан тушаалын цалингийн доод хэмжээг шинэчлэн батлагдсан зэрэг нь голлон нөлөөлсөн байна.

Харин татварын бус орлогын төлөвлөгөөг 4,223.4 сая төгрөгөөр төвлөрүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 2,229.7 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, 47.2 хувь буюу 1,993.7 сая төгрөгөөр тасалсан байна.

Татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулахад дараах байдалтай байна

Хүснэгт №6 Татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая.төг/

Татварын бус орлогын төрөл	Нийт дүн		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
А	1	2	3=2-1
Хадгаламжийн хүүгийн орлого	3,240.4	808.0	(2,432.4)
Түрээсийн орлого	-	47.5	47.5
Торгуулийн орлого	880.0	1,011.5	131.5
Бусад орлого	50.0	84.4	34.4
Хөрөнгө борлуулсны орлого	53.0	278.4	225.4
Нийт орлогын дүн	4,223.4	2,229.7	(1,993.7)

Татварын бус орлогын төлөвлөгөөний хэрэгжилтийг нэр төрлөөр харуулбал:

- **Торгуулийн орлого** төлөвлөгөөнөөс 131.5 сая төгрөгөөр давж биелжээ. Энэ нь тодорхойлох боломжгүй орлого бөгөөд тайлант онд төлөвлөсөн хэмжээнээс 131.5 сая төгрөг буюу 14.9 хувиар давж биелсэн байна.
- **Бусад орлого** төлөвлөгөөнөөс 34.4 сая төгрөгөөр давж биелсэн байна. Үүнд Санхүүгийн хяналт дотоод аудит болон Төрийн аудитын газраас тогтоосон төлбөрийн актын орлогууд, бусад нэр заагдаагүй урьдчилан тооцох боломжгүй орлого ордог тул гүйцэтгэлээр 34.4 сая төгрөг буюу 31.6 хувиар давж биелсэн байна.
- **Хөрөнгө борлуулсны татварын орлогыг** 53.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 278.4 сая төгрөгийг төвлөрүүлэн 225.7 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Энэ нь өмнөх жилүүдэд ковид цар тахлын улмаас хөрөнгийн дуудлага худалдаа зохион байгуулаагүй, борлуулах хөрөнгө их хэмжээгээр хуримтлагдсаныг тус онд борлуулсантай холбоотой байна.

Татварын болон татварын бус орлогыг 15,566.4 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 137.8 хувь буюу 5,887.2 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Харин Дэрэн, Сайхан-Овоо, Говь-Угтаал, Өндөршил, Дэлгэрхангай, Эрдэнэдалай сумд орлогын төлөвлөгөөг 0.2-27.7 хувиар тасалжээ. Мөн орлогыг нэр төрлөөр авч үзэхэд үйл ажиллагааны орлого, малын тоо толгойн албан татвар, улсын тэмдэгтийн хураамж, байгалийн нөөц ашигласны татвар, ус, рашааны нөөц ашигласны төлбөр, ан амьтны нөөц ашигласны төлбөр, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, хог хаягдлын үйлчилгээний хураамж орлогууд тасарчээ.

Иймд татварын болон татварын бус орлогыг төлөвлөхдөө тайлант оны онцлог, эдийн засгийн нөхцөл байдлын өөрчлөлт, өмнөх оны гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж батлуулах, орлогыг нэр төрлөөр төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллах талаар сумдын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар Засаг дарга нарт зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлага, зөвлөмжүүдийг тус тус хүргүүлсэн.



Харин хадгаламжийн хүүгийн орлогыг 3,240.4 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 808.0 сая төгрөгийн биелэлттэй байна. Төлөвлөгөө өндрөөр тасарсан нь Сангийн яамнаас

анх батлагдсан 700.0 сая төгрөгийг 2,540.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, Засгийн газарт төлөх урт хугацаат өр төлбөрийг тайлант оны татварын орлогоос бүрдүүлнэ гэж төлөвлөсөнтэй холбоотой байна. Энэ нь өмнөх онуудын төлөвлөгөө, гүйцэтгэлд үндэслээгүйгээс орлого тасрах эрсдлийг бий болгож байгаа тул Үндэсний аудитын газраар дамжуулан Сангийн яаманд биелэгдэхүйц бодит тоон мэдээнд үндэслэж, төлөвлөх талаар анхаарч ажиллах санал хүргүүлээ.

Улсын төсөвт төвлөрүүлэх аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогыг 700.0 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 754.6 сая төгрөгийг төвлөрүүлж, 107.8 хувиар давуулан биелүүлсэн байна. Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулбал:

График №2 ААНОАТ-ын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая.төг/



Тайлант оны төлөвлөгөөг өмнөх оны гүйцэтгэлээс 1.8 дахин нэмэгдүүлэн баталсан байна. Сангийн сайдын 2022 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн А/07 дугаар тушаалаар батлагдсан "Аж ахуй нэгжийн орлогын албан татварын орлогыг аймаг, нийслэлийн төсөвт хуваарилах, үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам"-ын 3.5⁴-т заасны дагуу улсын төсөвт төвлөрүүлсэн орлогоос орон нутгийн төсөвт хуваарилсан байна.




Орлогын төлөвлөгөө материаллаг дүнгээр тасалсан ч, биелэх боломжтой дараах 2 нэр төрлийн орлогууд байна. Үүнд:

- **Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн орлого:**

График №3 Түгээмэл тархацтай ашигт малтмал /сая.төг/

2023 оны байдлаар аймгийн хэмжээнд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 55 аж ахуй нэгж, байгууллага байгаа боловч тогтмол үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуй нэгж, байгууллага байхгүй байна.

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэд өөрсдийн хөрөнгөөр барилга байгууламж, өргөтгөл, их засварын ажлуудыг хийж байгаа ч холбогдох албан тушаалтнууд Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д /Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа, Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээдэд олгоно/, тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1-д /аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон уурхайн талбайг тусгах/ заасны дагуу арга хэмжээ зохион байгуулж ажиллаагүйтэй холбоотой дээрх орлого жил бүр тасарч ирсэн байна.



Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн дагуу орлого бүрдүүлэлтийн бэлтгэл ажлыг сум бүрд зохион байгуулан, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах барилга, байгууламжид ашиглах түгээмэл тархацтай ашигт малтмалын тооцоонд үндэслэн сумдад орлогын төлөвлөгөөг хуваарилснаар орлого бүрэн биелэх боломжтой байна.

Иймд аймгийн Засаг дарга Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд⁵ заасан бүрэн эрхийнхээ хүрээнд шаардлагатай сумдад тусгай зөвшөөрөл олгох, зөвшөөрөл бүхий аж ахуй нэгжийн үйл ажиллагааг хянах, тогтмолжуулах ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

⁴ /Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасны дагуу аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогыг төсвийн тогтворжуулалтын санд хуваарилж тэнцвэржүүлэн тооцсон орлогоос аймаг, нийслэлийн төсөвт хуваарилна/

⁵ 11.2.1.түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газраас гаргасан шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

11.2.2.харьяалах нутаг дэвсгэрт нь тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг зориулалтаар ашиглуулах, зөрчил гаргасан тохиолдолд уг зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авах;

11.2.3.хүний эрүүл мэнд, байгаль орчин, нөхөн сэргээлт, уурхайн хаалт болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн талаар хүлээсэн үүргээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих;


• **Малын тоо толгойн албан татварын орлого:**

Орлогын төлөвлөгөөний биелэлт 1,157.0 сая буюу 74.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Төлөвлөгөөний биелэлтийг сумдаар харьцуулж үзэхэд Хулд, Луус, Адаацаг сумд 104.1-138.6 хувиар давуулсан байна. Малын тоо толгойн албан татварыг 2021 онд 115.3 хувь, 2022 онд 84.1 хувьтай тус тус төвлөрүүлжээ.

2023 оны байдлаар сумдын ИТХ-аас малын тоо, толгойн албан татварын хэмжээг тогтоохдоо бэлчээрийн ашиглалт, даац хэтрэлтийн хэмжээг харгалзан үздэггүйгээс бэлчээрийн даац хэтрэлт багатай Дэлгэрхангай, Сайхан-Овоо, Өлзийт сумдын татварын хэмжээг бусад сумдаас харьцангуй өндрөөр тогтоож, бэлчээрийн даацын хэтрэлттэй Дэрэн, Хулд, Гурвансайхан сумдын татварын хэмжээг багаар тогтоосон байна.

Иймд аймгийн Засаг даргаас сумдад малын тоо толгойн албан татварын хэмжээг бэлчээрийн даацтай уялдуулан тогтоож, орлогыг төлөвлөн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

График №4 Малын тоо толгойн албан татвар




2. ТӨСВИЙН НИЙТ ЗАРДЛЫГ ТӨЛӨВЛӨЖ, ЗАРЦУУЛАХДАА САНГИЙН ЯАМНААС ӨГСӨН ЧИГЛЭЛ, ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ЗАРИМ САНАЛ, ДҮГНЭЛТИЙГ ХАРГАЛЗАН ҮЗДЭГГҮЙ, ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬ, ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙТЭЙ ХОЛБООТОЙ БАЙНА.

2.1 Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн төслийг боловсруулж, батлахдаа Сангийн яамнаас өгсөн чиглэл, Төрийн аудитын байгууллагын санал, дүгнэлтийг бүрэн авч үзэхгүй байна.



Сангийн яам Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 төсвийн төслийн урсгал зардлыг 11.7 хувиар, хөрөнгийн зардлыг 88.7 хувиар тус тус бууруулан хянасан байна.

График №5 Төсвийн зардлын төсөл



Урсгал зардлаас аймаг болон сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн урамшуулал болон урсгал засварын зардлыг 3,208.7 сая төгрөгөөр бууруулж, зарим байгууллагын төсвийг бага хэмжээгээр өөрчлөн 22,918.5 сая төгрөгөөр баталсан байна. Харин бусад хөрөнгийн зардлыг 8,710.3 сая төгрөгөөр бууруулан их засварын зардалд 1,083.3 сая төгрөгийг хянасан байна.

Энэ нь орон нутгийн 2023 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл болон аймгийн 2023 оны төсвийн төсөлд Төрийн аудитын газраас төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх санал дүгнэлтэд

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3-т / *Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох* /, Засгийн газрын 2022 оны 404 дугаар “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” тогтоолын 1-т / *“Журам батлах тухай” Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 402 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Иргэдийн Төлөөлөгчдийн*

11.2.4. түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн өргөдлийг хянах;

11.2.5. харьяалах нутаг дэвсгэрт нь хамаарах түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох;

11.2.6. түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн гүйцэтгэлийг хянах

Хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журам"-ын 2.3 дахь заалтын "зардал, урамшууллын" гэснийг, мөн журмын хавсралтын "Тайлбар: Зардлын нийтлэг жишигт төлөөлөгчид олгох урамшууллыг нэмж тооцно." гэснийг тус тус хассугай /, Засгийн газрын 2021 оны 43 дугаар "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын 1.3⁶, 1.4⁷-д заасны дагуу аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн урамшуулал, төсвийн байгууллагуудын урсгал засвар, тавилга эд хогшлын зардлыг тооцохгүй, нэмэхгүй байх гэж өгсөн санал, чиглэлийг хангаж ажиллаагүй байна.

Орон нутгийн төсвийн төслийг боловсруулахдаа эрх бүхий байгууллагаас өгсөн чиглэл, удирдамж, санал, дүгнэлтийг харгалзан үзээгүй нь хууль тогтоомж зөрчигдөх, төсвийг үр ашиггүй, хэмнэлтгүй зарцуулах үр дагавартай байна. Иймд төсвийн төслийг боловсруулж хүргүүлэхдээ эрх бүхий байгууллагаас өгсөн чиглэл, заавар, санал, дүгнэлтийг харгалзан үзэх шаардлагатай байна.

Дундговь аймгийн болон сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны жилийн эцсийн тогтоолуудаар орон нутгийн 2023 оны төсвийн эх үүсвэр болон зарлагыг 46,457.6 сая төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт №7 Батлагдсан төсвийн зардлын анх батлагдсан төсөв, тодотгосон төсөв /сая.төг/

Зарцуулах эрх	Яам хянасан	Тайлант он		Зөрүү	
		Анх батлагдсан	Тодотгол	Яамны хяналтаас	Анхны батлагдсанаас
Урсгал зардал	22,918.5	23,849.6	30,749.5	7,831.0	6,899.9
Хөрөнгийн зардал	1,083.3	18,307.1	23,355.8	22,272.5	5,048.7
Зээлийн эргэн төлөлт		4,300.9	2,792.5		-1,508.4
Нийт дүн	24,001.8	46,457.6	56,897.8	32,896.0	10,440.2

Сангийн яамны хяналт хийдэггүй дараах зардлуудыг аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан байна. Үүнд:

- Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт 4,300.9 сая төгрөг;
- Аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх төсөл хөтөлбөр 18,554.1 сая төгрөг.

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2023 оны 07 сарын сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчийн үндсэн цалинг нэмсэн, бараа материалын үнийн өсөлт зэргээс шалтгаалан 2023 оны 6 дугаар сард аймаг болон сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор улсын төсвөөс 4,892.6 сая, сумдын орон нутгийн төсвөөс 5,547.6 сая төгрөгийг нэмж, төсвийн эх үүсвэр болон зарлагыг 56,897.8 сая төгрөг болгон тодотгол хийсэн байна. 2023 оны жилийн эцэст төсвийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангах, үүссэн өр төлбөрийг барагдуулах зорилгоор төсвийн шууд захирагчдын батлагдсан төсөв хооронд 549.9 сая төгрөгийн зохицуулалт хийсэн байна.

2.2 Төсвийн зарцуулалттай холбоотой нийт 470.7 сая төгрөгийн зөрчил илэрсний 34.1 хувь нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил байна.



Дундговь аймгийн 2023 оны төсвийн зарлагын төлөвлөгөөг 56,897.8 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 82.0 буюу 46,677.2 сая төгрөгийг зарцуулсан байна. Төсвийн гүйцэтгэлийн нийт зардлын 61.0 хувийг урсгал зардал, 35.9 хувийг хөрөнгийн зардал, 3.1 хувийг эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл эзэлсэн байна.

Хүснэгт №2 Төсвийн зардлын батлагдсан төсөв, гүйцэтгэл /сая.төг/

Үзүүлэлт	Нэгтгэл		Зөрүү	Хувь
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		

⁶ төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишигээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх,
⁷ энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх;

Урсгал зардал	30,749.5	28,487.9	2,261.6	92.6
Хөрөнгийн зардал	23,355.8	16,784.4	6,571.4	71.9
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан зээл	2,792.5	1,404.9	1,387.6	50.3
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	56,897.8	46,677.2	10,220.6	82.0

Нийт зардлын гүйцэтгэл 82.0 хувьтай байгаа нь хөрөнгийн зардлын гүйцэтгэл, эргэж төлөгдөх төлбөрийг хассан зээлийн гүйцэтгэлүүд 50.3-71.9 хувьтай байгаатай холбоотой байна. Энэ нь орон нутгийн хөгжлийн сан, хоршоо хөгжүүлэх сангийн ТАХ-ний хэрэгжилт хангалтгүй байгаа нь нөлөөлсөн байна.

Төсвийн зарлагын зарцуулалтыг зардал бүрээр харуулбал:

Урсгал зардал

Хүснэгт №8 Санхүүгийн аудитаар зардалтай холбоотой зөрчлийн ангилал /сая.төг/

Төсөвт байгууллагуудын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар урсгал зардалтай холбоотой нийт 470.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь урсгал зардлын гүйцэтгэлийн 1.6 хувийг эзэлж байна.

Илэрсэн зөрчлийг агуулгаар харвал:

№	Зөрчлийн агуулга	Акт	Албан шаардлага	Зөвлөмж
1	Анхан шатны баримтын бүрдэл дутуу	-	164.3	1.6
2	Зориулалт бус	-	49.3	-
3	Зардлыг илүү тооцож олгосон	34.6	-	-
4	Хууль журмын хэрэгжилт	-	37.3	23.0
5	Төрийн хэмнэлтийн тухай хууль	5.6	94.9	60.0
Нийт		40.2	345.9	84.6

- Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар зарлагын гүйлгээ хийсэн зөрчил нийт зөрчлийн 53.4 хувь буюу 165.9 сая;
- Хууль журмын хэрэгжилтийг хангаагүй зөрчил 19.4 хувь буюу 60.3 сая;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй зөрчил 34.1 хувь буюу 160.4 сая;
- Төсвийг зориулалт бусаар буюу эдийн засгийн ангилал гүйлгэн зарцуулсан 15.9 хувь буюу 49.3 сая;
- Зардлыг тооцоолсон болон норм, норматив, хууль, журмаас хэтрүүлэн илүү олгосон 11.3 хувь буюу 34.6 сая төгрөгийн зөрчлүүд эзэлж байна. /Хавсралт-3/



Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 160.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс 94.8 сая төгрөгийн зөрчилд 9 хугацаатай албан шаардлага хүргүүлж, 5.6 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоон, 60.0 сая төгрөгийн зөрчилд 1 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн байна.

№	Төрийн хэмнэлтийн заалт	Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж
1	ТХХ 12.1.3.	0.6	-	-
2	ТХХ 13.1.5.	-	-	60.0
3	ТХХ 14.4.	-	91.4	-
4	ТХХ 15.1.3.	1.7	-	-
5	ТХХ 15.1.5.	3.3	2.5	-
6	ТХХ 15.2.3.	-	1.0	-
7	ТХХ 9.2.	-	-	-
		5.6	94.9	60.0

Илэрсэн зөрчлийг агуулгаар харвал төрийн хэмнэлтийн хуулийг хамгийн их зөрчин цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй 91.4 сая төгрөг, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хуулиар батлагдсанаас хойш түүний төсөвт өртөг нэмэгдүүлэх үр дагавар бүхий нэмэлт шаардлагыг зохиогч, ашиглагч, захиалагчийн хяналт тавих этгээд гаргахгүй байх 60.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Зөрчлийн дүнгээс харахад төрийн хэмнэлтийн тухай хуулийн цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглох заалтыг хэрэгжүүлээгүй нь цахим дэлгүүрийн талаарх ойлголт дутмаг, хэрхэн яаж бараа, үйлчилгээг худалдан авахаа мэддэггүй, зарим бараа, үйлчилгээ бусад дэлгүүрээс үнэтэй гэсэн шалтгаанаар худалдан авалт хийдэггүй байна.

Цахим дэлгүүрээр худалдан авалт хийснээр тендер зарлаж цаг хугацаа алдаж, бичиг хэргийн зардал нэмэгдэхгүй, баталгаатай, чанартай бараа үйлчилгээг авах үр дүнтэй юм.

Иймд цахим дэлгүүрийн худалдан авалттай холбоотой мэдээллийг орон нутгийн төсөв захирагчдад таниулах сургалт, сурталчилгааг хийж, хууль, журмын хэрэгжилтийг хангуулан ажиллахад анхаарах шаардлагатай байна.



Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний гүйцэтгэл 68.4 хувьтай байна.

Дундговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн хөрөнгийн зардлын гүйцэтгэл 28.1 хувь буюу 6,571.5 сая төгрөгийг дутуу зарцуулсан байна. Хөрөнгийн зардалд аймаг, сумын ЗДТГ-ын бусад хөрөнгийн зардал болон ОНХС-ийн зардлууд багтаж байна.

Аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар ОНХС-гийн зардлын төлөвлөгөөг 18,554.1 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 68.4 хувь буюу 12,685.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт №9 Аймаг, сумын ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая.төг/

№	Сумын нэрс	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Хувь	
		тоо	өртөг	тоо	өртөг	тоо	өртөг
1	Дэлгэрцогт	12	248.3	10	227.5	83.3	91.6
2	Дэрэн	25	478.8	21	382.8	84.0	80.0
3	Говь-Угтаал	15	388.7	8	285.1	53.3	73.4
4	Цагаандэлгэр	18	165.0	18	135.2	100.0	81.9
5	Баянжаргалан	14	838.7	11	284.9	78.6	34.0
6	Өндөршил	13	699.1	10	571.7	76.9	81.8
7	Гурвансайхан	13	963.5	5	148.7	38.5	15.4
8	Өлзийт	43	1,384.0	30	779.3	69.8	56.3
9	Хулд	21	611.7	20	551.0	95.2	90.1
10	Луус	14	397.6	13	313.1	92.9	78.7
11	Дэлгэрхангай	34	715.9	23	442.1	67.6	61.8
12	Сайхан-Овоо	21	513.1	17	425.9	81.0	83.0
13	Эрдэнэдалай	60	1,427.9	53	1,219.8	88.3	85.4
14	Адаацаг	16	601.4	8	396.0	50.0	65.8
15	Сайнцагаан	47	1,234.9	37	807.2	78.7	65.4
16	Аймгийн төв	44	7,885.5	37	5,715.3	84.1	72.5
Дүн		410	18,554.1	321	12,685.7	76.4	68.4

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулиар Дундговь аймагт орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас ОНХС-д 11,875.4 сая төгрөгийн орлогын шилжүүлэг олгохоор баталснаас гүйцэтгэлээр 11,563.4 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон байна. Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн “Аймгийн 2023 оны төсөв тодотгож батлах тухай” 25 дугаар тогтоолоор аймгийн төсвийн захирагчаас сумдын төсвийн ерөнхийлөн захирагчдад 6,024.2 сая төгрөгийн Орон нутгийн хөгжлийн сангийн орлогыг олгохоор баталсан байна. Гүйцэтгэлээр сумдад 5,711.8 сая төгрөгийн орон нутгийн хөгжлийн сангийн орлогыг шилжүүлснээс Гурвансайхан суманд 312.4 сая төгрөгийн орлогыг дутуу олгож, тухайн суманд хийгдэх 460.0 сая төгрөгийн өртөгтэй цэвэрлэх байгууламжийн ажил хэрэгжээгүйгээс сумын нийт гүйцэтгэл 15.4 хувьтай байна.

Аймгийн болон сумын ОНХС-гийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 5,914.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 7.3 сая төгрөгийн 1 алдааг залруулж, 5,806.7 сая төгрөгийн зөрчилд 46 хугацаатай албан шаардлага хүргүүлж, 1.2 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоон, холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.

Мөн төсөв захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийт ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ны төлөвлөлт, зарцуулалт, хяналттай холбоотой зөрчлийн агуулгад дүн шинжилгээ хийж, зөрчил гарсан учир шалтгаан, үр дагаврыг тооцож, зөрчлийг арилгах чиглэлээр төлөвлөгөө боловсруулж, сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг тайлант хугацааны явцад хийж, жилийн эцсийн тайлан гарахаас өмнө хэрэгжилт, үр дүнг тооцож ажиллах талаар Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар зөвлөмж хүргүүлсэн байна.



Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих ТАХ-ний гүйцэтгэл 88.9 хувьтай байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд нийт 3,491.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 18 ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөж баталсныг аймгийн ИТХ-ын тогтоолоор 2 удаа өөрчлөлт оруулан, нийт дүнг 1,744.8 сая төгрөгөөр буюу 50.0 хувиар нэмэгдүүлэн 43 төсөл арга хэмжээ болгож баталсан байна.

Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл арга хэмжээг хийж гүйцэтгүүлэхээр нийт 4,984.1 сая төгрөгийн гэрээ байгуулжээ. Гүйцэтгэлээр тайлант онд 4,431.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон нь 88.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт №10 Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ТАХ-ний гүйцэтгэл					/сая.төг/
№	ХАА-ны төрөл	Төсөвт өртөг	Гэрээний үнэ	Гүйцэтгэл	Санхүүжилтийн гүйцэтгэлийн хувь
1	Эрх шилжүүлсэн	635.3	796.6	635.3	79.7
2	Тендер зарласан	3,132.8	2,922.8	2,596.8	88.8
3	Шууд гэрээ байгуулсан	1,418.1	1,264.7	1,199.3	94.8
	дүн	5,186.3	4,984.1	4,431.4	88.9

“Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар нийт 818.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 83.6 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлж, аймгийн Засаг даргад 735.0 сая төгрөгийн ОНХО-ыг холбогдох хууль, тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөж, гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллах, хөрөнгө оруулалтаас бий болсон хөрөнгийг санхүүгийн тайланд бүрэн, үнэн зөв тусгах болон хэрэгжүүлсэн хөтөлбөр арга хэмжээний үр дүнг тооцож ажиллах талаар зөвлөмжүүдийг хүргүүлсэн байна.

Хоршоо хөгжүүлэх сангаас олгох зээлийн олголт 50.3 хувьтай байна.

Эргэн төлөгдөх зээлийн төлөвлөгөөг 2,792.5 сая төгрөгөөр баталснаас 50.3 буюу 1,404.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт №11 ХХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэл, зөрүү, биелэх боломж								/сая.төг/
№	Сумын нэр	2022 оны дансны үлдэгдэл	2023 онд төлөгдсөн зээл	Нийт орлого	Зээл олголт		Зөрүү	
					Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэл	Биелэх боломж
	Код	1	2	3	4	5	6=4-5	7=3-4
1	Дэлгэрцогт	56.3	43.6	99.9	151.5	141.2	10.3	-41.3
2	Дэрэн	141.8	67.1	208.8	183.6	106	77.6	102.8
3	Говь-Угтаал	17.7	17.3	35.1	228.2	40	188.2	-4.9
4	Цагаандэлгэр	123.3	33.4	156.7	181.3	125	56.3	31.7
5	Баянжаргалан	97.9	38.7	136.6	151.1	137	14.1	-0.4
6	Өндөршил	175.3	31.9	207.3	79	0	79	207.3
7	Гурвансайхан	214.3	53.2	267.5	82.2	0	82.2	267.5
8	Өлзийт	68.6	26.2	94.8	158.3	81.5	76.8	13.3
9	Хулд	53.3	66.9	120.2	172.5	115	57.5	5.2
10	Луус	138.9	44.8	183.8	97.8	0	97.8	183.8
11	Дэлгэрхангай	3.3	4.5	7.7	218.2	158.4	59.8	-150.7
12	Сайхан овоо	60.1	56.6	116.7	84	25	59	91.7
13	Эрдэнэдалай	148.9	14.2	163.1	209.7	0	209.7	163.1
14	Сайнцагаан	947.8	372.6	1,320.50	656	348	308	972.5
15	Адаацаг	152.5	5.5	158	139	127.8	11.2	30.2
	Нийт дүн	2,399.9	876.6	3,276.5	2,792.5	1,404.9	1,387.6	1,871.8

Эргэж төлөгдөх төлбөрийг хассан зээл нь 15 сумын хоршоо хөгжүүлэх сангийн зээл бөгөөд зээл олголт 50.3 хувьтай, гүйцэтгэл дутуу байгаа нь Өндөршил, Гурвансайхан, Луус, Эрдэнэдалай сумд зээл олгоогүйтэй холбоотой байна. Мөн батлагдсан 2,792.5 сая төгрөгийн төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэх боломжтой эсэхийг судлахад, тайлант онд зээлийн эх үүсвэрт нийт 3,276.5 сая төгрөг төвлөрч, төлөвлөгөө бүрэн биелэх боломжтой харагдаж байна. Гэвч сумдаар харахад Дэлгэрцогт, Говь-Угтаал, Баянжаргалан, Дэлгэрхангай сумд батлагдсан төлөвлөгөөний дагуу ХХС-гаас зээл олгох боломжгүй байна. Энэ нь ХХС-ийн хугацаа хэтрэлтэй зээл буюу сангийн авлагын үлдэгдэл өндөр, авлагыг барагдуулах арга хэмжээ хангалтгүй байгаатай холбоотой байна.

Иймд ХХС-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 10 суманд тайлант онд төлөгдөх үндсэн зээл, зээлийн хүүг төлөөгүй, хугацаа хэтрүүлснээс Хоршоо хөгжүүлэх санд нийт 88.2 сая төгрөгийн хохирол учруулсан зөрчилд холбогдох төлбөрийн акт, албан шаардлагуудыг хүргүүлсэн байна.

Харин зээл олголт муу сумдаас тодруулахад ХХС-ийн мэргэжилтэн байхгүй, бусад төрийн албан хаагч хавсардаг, шаардлага хангасан төсөл арга хэмжээ ирдэггүй, сумдад идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг хоршоо байхгүй, урьд оны зээлийн үлдэгдэл өндөр болохоор олгоогүй зэрэг шалтгааныг тайлбарласан.

ХХС-ийн эх үүсвэр бүрдэхгүй байх нь төсөл хэрэгжүүлэгч нарт зээл олгогдохгүй, эргэлтийн хөрөнгө ашиглалтгүй болж, орон нутгийн иргэд төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх боломжийг бууруулж, иргэдийн амьдрал, сумын хөгжилд сөргөөр нөлөөлөх үр дагавартай байна.


Иймд Төсвийн тухай хуулийн 69.1-д /Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна/ заасны дагуу Санхүүгийн хяналт, аудитын албаар хоршоо хөгжүүлэх сангийн зээл олголт хангалтгүй олгогдсон шалтгааныг тодруулж, эргэлтийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах талаар судлуулан, дүгнэлт, санал гаргуулж, арга хэмжээ шаардлагатай байна. /Хавсралт-1/

2.3 Төсвийн тухай хуулийн дагуу ОНХС-ийн дансанд төвлөрүүлэх 281.4 сая төгрөгийн хандив, тусламжийг аймаг, сумдын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, урсгал зардалд зарцуулсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэмэлт санхүүжилтийн дансанд орсон орлогыг нэр төрлөөр бүртгэн, зардлын зүйл тус бүрээр эрх нээн зарцуулж, тайлагнажээ. Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд 1,486.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,355.6 сая төгрөгийг зарцуулан, 131.1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн хавсралт 2-т харуулав.

График №6 Нэмэлтийн орлогын задаргаа



Нэмэлт төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг диаграммаар харуулбал нийт орлогын 45.4 хувийг дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө, 35.7 хувийг төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого, 18.9 хувийг орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжийн орлого тус тус эзэлж байна. Тайлант оны нэмэлт төсвийн эх үүсвэрийг өмнөх онтой харьцуулахад 1,973.8 сая төгрөгөөр буурсан нь орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж 71.4 хувь буюу 1,408.6 сая төгрөгөөр буурсантай холбоотой

байна.

Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №12 Нэмэлт санхүүжилтийн орлогыг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулсан /сая.төг/

№	Нэмэлт төсвийн эх үүсвэр	2022	2023	Өсөлт/Бууралт
1	Орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	1,690.0	281.4	-1,408.6
2	Дээд шатны төсвийн захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	993.8	675.0	-318.8
3	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	776.7	530.3	-246.4
Нийт дүн		3,460.4	1,486.7	-1,973.8

Орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж

Тус онд төсвийн ерөнхийлөн захирагч 281.4 сая төгрөгийн хандив, тусламжийг авсан нь өмнөх оноос 6 дахин бага байна. Хандив, тусламжийн орлого буурсанд дараах шалтгаанууд нөлөөлжээ. Үүнд:

1. Өмнөх онд аймаг байгуулагдсаны түүхт 80 жилийн ой тохиож, ойг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотой зардлыг санхүүжүүлэх зорилгоор иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас 1,455.0 сая төгрөгийн хандивыг авч зарцуулсан;

2. Тайлант онд зарим сумд уул уурхайн компаниас нийгмийн хариуцлагын хүрээнд өгсөн хандив, тусламжийг орон нутгийн хөгжлийн сангийн дансанд хүлээн авч зарцуулсантай холбоотой байна.


2023 оны нийт хандив, тусламжийн 92.1 хувь буюу 259.2 сая төгрөг нь нийгмийн хариуцлагын хүрээнд олгогдсон, 7.9 хувь буюу 22.2 сая төгрөг нь “Уяхан замбуу тивийн наран” урлагийн нэгдсэн арга хэмжээний орлого байна.

Хандив, тусламжийг аймаг, сумдын Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансаар авч байгаа нь Төсвийн тухай хуулийн 60.2.5-д /Тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг/, 60.2.9-д /Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан гэрээний дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламж/ заасныг зөрчиж байна. Энэ нь хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх, төсвийг хяналтгүй, зориулалт бусаар зарцуулагдах эрсдэлийг бий болгож байна.

Иймд нийгмийн хариуцлагын хүрээнд олгогдож байгаа хандив тусламжийг Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.5, 60.2.9-д заасны дагуу ОНХС-гийн дансанд хүлээн авч орон нутгийн хөгжлийг дэмжих арга хэмжээнд зарцуулж байх шаардлагатай байна.

Нэмэлт төсвийг эрх нээлгэж, нийт зардлын 88.0 хувийг бараа, ажил үйлчилгээний зардалд зарцуулжээ.

График №7 Нэмэлтийн дансны зарцуулалт



Нэгтгэсэн тайлангийн нэмэлт санхүүжилтийн зардалд 1,486.7 сая төгрөгийг тайлагнаснаас бараа, ажил үйлчилгээний зардалд 1,314.5 сая төгрөг, татаас, урсгал шилжүүлэгт 168.4 сая төгрөг, хөрөнгийн зардалд 3.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Үүнийг графикаар харууллаа.

Нийт зардлын дийлэнх хувийг аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн зардал эзэлж байна. /Хавсралт-2/

3. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙЖ, ӨМНӨХ АУДИТЫН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЛТТАЙ ГЭЖ ҮЗСЭН БАЙНА.

3.1 Хяналт, шинжилгээ, үнэлгээгээр Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 94.6 хувьтай байна.



Тайлант онд аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн 433 арга хэмжээг хэрэгжүүлэхээр яамд, сайд нартай гэрээг байгуулсан байна.

Хүснэгт №13 Яамдтай байгуулсан гэрээний гүйцэтгэлийг үнэлсэн үнэлгээ /сая.төг/

№	Яам / сайд/-ын нэр	2022			2023		
		Арга хэмжээнй тоо	ХШҮ-ний үнэлгээ	Дээд газрын үнэлгээ	Арга хэмжээнй тоо	ХШҮ-ний үнэлгээ	Дээд газрын үнэлгээ
1	Монгол улсын Шадар сайд	39	95.7		22	93.4	
2	Уул уурхай хүнд үйлдвэрийн сайд	21	93.8	82	23	95.4	83.4
3	ЗГХЭГ-ын дарга	26	98.2		37	93.0	
4	БШУЯ	100	93	93	118	93.8	
5	Эрчим хүчний яам	14	90	98.2	21	94.7	86.7
6	Барилга хот байгуулалтын яам	101	98.1	95.2	84	98.8	97.5
7	Эрүүл мэндийн яам	91	84.4	86.2	89	82.3	74.7
8	Зам тээврийн хөгжлийн яам	29	81.5	66.5	20	83.5	
9	ХХААХҮЯ	48	90.9	79.8	44	95.3	
10	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам	128	88.4	78.5	102	90.3	

11	БОАЖЯ	60	97.3	94.7	38	96.7	85.5
12	Сангийн яам	45	99.3	91.3	48	98.7	93.7
13	Хууль зүй дотоод хэргийн яам	38	90.8	83.7	30	97.3	91.7
14	Соёлын яам	65	90.3	84.3	68	97.0	89.3
15	Батлан хамгаалах яам	31	90.9	91	31	98.1	
16	Гадаад харилцааны яам	10	90	90	11	100.0	
17	Эдийн засаг, хөгжлийн сайд	9	93.3	91.1	12	91.6	95.8
18	Цахим хөгжил, харилцаа холбооны сайд	18	99.4	97.7	22	99.8	97.7
19	Батламж	7	99		7	98.5	
Дүн		881	92.9	87.7	433	94.6	89.6

Өмнөх онд Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 881 арга хэмжээг 92.9 хувь, яамдын дунджаар 87.7 хувьтай үнэлсэн байхад төсвийн гүйцэтгэл 90.5 хувь зарцуулагдсан байна. Харин тайлант онд Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 433 арга хэмжээг 94.6 хувь, яамдын дунджаар 89.6 хувьтай үнэлсэн байхад төсвийн гүйцэтгэл 82.0 хувь зарцуулагджээ. Арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээ 1.9 хувиар өссөн байхад төсвийн гүйцэтгэл 8.5 хувиар буурсан байна. ТӨЗ-ийн 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг 95.5 хувийн хэрэгжилттэй тайлагнасан боловч хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгээгүй байна.

3.2 Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийн дагуу аймгийн Засаг дарга, Татварын хэлтсээс авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд тодорхой үр дүнд хүрсэн байна.


Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар аймгийн Засаг даргад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, ерөнхий боловсролын сургуулиудын дотуур байрны халаалтын талбайг шинэчлэн хэмжиж, гэрээнд тавих хяналтыг сайжруулах зөвлөмжүүдийг хүргүүлсэн.

Зөвлөмжийн хүрээнд төлөвлөгөө гарган аймгийн хэмжээний 163 төсөв захирагч нарыг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар сургалт зохион байгуулснаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил өмнөх оноос 55.6 хувиар буурсан байна. Мөн ерөнхий боловсролын сургуулиудын дотуур байрны халаалтын талбайг тухайн байгууллага болон мэргэжлийн байгууллагатай хамтран хэмжилт хийлгэж гэрээг шинэчлэн байгуулсан байна.

Харин аймгийн Татварын газарт тасарсан татварын орлогыг нэр төрлөөр нь биелүүлэхэд анхаарч, тасарсан шалтгааныг тодруулан дүн шинжилгээ хийх, тайлант оны онцлог, эдийн засгийн нөхцөл байдлын өөрчлөлттэй уялдуулан орлогыг бодитой төлөвлөх, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах, хүний нөөцийг бүрэн бүрдүүлэх, тогтвортой ажиллах нөхцөлийг хангах зөвлөмжүүдийг хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

1. Тасарсан татварын орлогыг нэр төрлөөр нь биелүүлэхэд анхаарч, тасарсан шалтгааныг тодруулан дүн шинжилгээ хийх тухай зөвлөмжийн хэрэгжилтийг сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн аудитаар шалгахад нийт 10 сум хэрэгжүүлээгүй байна. Иймд өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй 8 суманд хугацаатай албан шаардлага, 2 суманд орлогыг нэр төрлөөр биелүүлэх зөвлөмжийг хүргүүлээ.
2. Хүний нөөцийн хувьд аймгийн Төрийн албаны салбар зөвлөлд сул орон тооны захиалга хүргүүлснээр Луус, Сайнцагаан сумдад татварын байцаагчтай болсон байна. Бусад орон тоо дутуу сумд байцаагчтай болоогүй бөгөөд аймгийн Татварын хэлтсийн байцаагчаар хавсарган гүйцэтгүүлж байна.
3. Тайлант оны орлогын төлөвлөгөөг батлахдаа өмнөх оны гүйцэтгэлээс 740.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна. Гүйцэтгэлээр 2,914.5 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн нь өмнөх оны гүйцэтгэлээс 348.5 сая төгрөгөөр илүү, тайлант оны төлөвлөгөөнөөс 392.2 сая төгрөгөөр тасарсан байна. Үүнийг орлогын төрлөөр харуулбал:

График №8 ТТХ-ийн зөрчил



Хүснэгт №14 Өмнөх аудитаар өгөгдсөн тасарсан орлогын тооцоолол				/сая.төг/	
Тасарсан орлогын төрөл	2022 оны гүйцэтгэл	2023 он		Зөрүү	
		төл	гүй	4=2-1	5=3-1
А	1	2	3	4=2-1	5=3-1
Үйл ажиллагааны орлого	418.1	450.0	304.0	31.9	(114.1)
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	170.3	151.1	179.0	(19.3)	8.7
Бууны албан татвар	16.4	18.5	18.3	2.1	1.8
Малд ноогдох албан татвар	1,018.3	1,563.6	1,157.0	545.3	138.7
Улсын тэмдэгтийн хураамж	140.6	160.0	142.8	19.4	2.1
Дуудлага худалдаа сонгон шалгаруулалт	155.3	155.0	289.0	(0.3)	133.7
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	10.6	108.5	16.5	97.9	6.0
Хадгаламжийн хүүгийн орлого	636.4	700.0	808.0	63.6	171.6
Нийт дүн	2,566.0	3,306.7	2,914.5	740.7	348.5

Хүснэгтээс харахад өмнөх онд тасарсан дээрх орлогуудаас 3 нэр төрлийн орлого 28.0-108.0 сая төгрөгөөр давж биелсэн байна. Мөн 7 нэр төрлийн орлого өмнөх оны гүйцэтгэлээс давж биелсэн байхад 1 нэр төрлийн орлого биелээгүй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт өгч байна. Үүнд:

1. Тайлант оны төсвийн саналыг Сангийн яам 1,221.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 2023 оны 06 дугаар сард тодотгол хийж, 56,897.8 сая төгрөг болгон улсын төсвөөс санхүүжих орлогыг 4,892.6 сая төгрөгөөр, орон нутгийн төсвөөс санхүүжих орлогын төлөвлөгөөг 5,547.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж төлөвлөсөн байна.
2. Татварын болон татварын бус орлого нийт дүнгээр 37.8 хувиар давсан боловч хүүгийн орлого 2,432.4 сая төгрөгөөр тасарсан нь Сангийн яамнаас өндрөөр төлөвлөж өгсөнтэй холбоотой байна. Мөн зарим орлого нэр төрлөөр тасарсан байна.
3. Анхны батлагдсан төсвийг 2023 оны 6 дугаар сард 56,897.8 сая төгрөг болгон тодотгол хийж, жилийн эцэст төсвийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангах, үүссэн өр төлбөрийг барагдуулах зорилгоор төсвийн шууд захирагчдын батлагдсан төсөв хооронд 549.9 сая төгрөгийн төсвийн зохицуулалтыг хийжээ.
4. Хоршоо хөгжүүлэх сангийн зээл олголтыг 2,792.5 сая төгрөгөөр баталснаас 50.3 буюу 1,404.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй зээл олголт хангалтгүй байна.
5. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 160.4 сая төгрөгийн зөрчлөөс 56.9 хувь буюу 91.4 сая төгрөгийн зөрчил нь цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.
6. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудаас нийт 1,486.7 сая төгрөгийн хандивыг аймаг, сумдын Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд хүлээн авсан нь Төсвийн тухай хуулийг зөрчсөн байна.
7. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 19 гэрээний 433 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт, шинжилгээ үнэлгээ хийж 94.6 хувьтай үнэлсэн байна.
8. Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилттэй холбоотой аймгийн Засаг дарга болон Татварын хэлтсээс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтийг үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Аймгийн Засаг даргад:

1. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд шаардлагатай сумдад тусгай зөвшөөрөл олгох, зөвшөөрөл бүхий аж ахуй нэгжийн үйл ажиллагааг хянах, тогтмолжуулах ажлыг зохион байгуулах;
2. Аймгийн Засаг даргаас сумдын Засаг дарга нарт малын тоо толгойн албан татварын хэмжээг бэлчээрийн даацтай уялдуулан тогтоож, орлогыг төлөвлөн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах талаар нэгдсэн бодлого чиглэл хүргүүлж, үр дүнг тооцож ажиллах;
3. Хоршоо хөгжүүлэх сангийн зээл олголт хангалтгүй олгогдсон шалтгааныг тодруулж, эргэлтийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, түүний гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах чиглэлийг Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанд хүргүүлэн үр дүнг тооцож ажиллах;
4. Цахим дэлгүүрийн худалдан авалттай холбоотой мэдээллийг төсвийн шууд захирагч нарт таниулах сургалт, сурталчилгааг хийж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллах;
5. Тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон хандив, тусламжийг Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.5, 60.2.9-т заасны дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн дансаар дамжуулан орон нутгийн хөгжлийг дэмжих арга хэмжээнд зарцуулах;

ДЭЭД ШАТНЫ БАЙГУУЛЛАГАД ХҮРГҮҮЛЭХ САНАЛ

Үндэсний аудитын газраар дамжуулан Сангийн яаманд дараах саналыг хүргүүлж байна.

Нөхцөл байдал:

Хадгаламжийн хүүгийн орлогыг 3,240.4 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 808.0 сая төгрөгийн биелэлттэй байна. Төлөвлөгөө өндрөөр тасарсан нь Сангийн яамнаас анх батлагдсан 700.0 сая төгрөгийг 2,540.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, Засгийн газарт төлөх урт хугацаат өр төлбөрийг тайлант оны татварын орлогоос бүрдүүлнэ гэж төлөвлөсөн зөрчил илэрсэн.

Энэ нь Сангийн сайдын 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 01/8031 үгээр албан бичгийн Орон нутгийн 2023 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэлийн 4-т /хүү, торгуулийн орлогыг нэр төрөл бүрээр бүртгэн, гүйцэтгэлийг төвлөрүүлэгч байгууллага бүрээр гаргах/ заасантай нийцэхгүй байна.

Санал:

Хадгаламжийн хүүгийн орлогыг өмнөх онуудын төлөвлөгөө, гүйцэтгэлд үндэслээгүйгээс орлого тасрах эрсдлийг бий болгож байгаа тул биелэгдэхүйц бодит тоон мэдээнд үндэслэж, төлөвлөх талаар Сангийн яаманд зөвлөмж хүргүүлэх саналтай байна.

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ,ТАЙЛБАР



ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

С.Буяннэмэхийн өргөн чөлөө 2-211, Нутгийн удирдлагын
ордон, 7-р баг, Сайнцагаан сум, Дундговь аймаг 48090
Утас/факс: 70592353 Цахим шуудан: info@dundgovi.gov.mn
Цахим хуудас: www.dundgovi.gov.mn

2024.04.24 № 01/573
танай 2024.04.23-ны № 01/63 -т

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн
захирагчийн 2023 оны төсвийн гүйцэтгэл”-д хийсэн
аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайланд өгөх санал тайлбар байхгүй болно.



Ц.МӨНХБАТ

4824140349

НЭГТГЭСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	56,897.83	46,677.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	30,749.48	28,487.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	25,725.35	23,606.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,596.10	8,327.31
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,093.87	1,021.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,339.71	6,185.39
2104	Хангамж, бараа материалын зардал	947.53	858.60
2105	Нормативт зардал	112.61	111.29
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,180.21	1,106.06
2107	Томилолт, зочны зардал	354.30	321.75
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,482.01	1,272.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,619.02	4,402.76
211	ХҮҮ	2,540.40	2,540.40
2111	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	-	-
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	2,540.40	2,540.40
212	ТАТААС	1,495.17	1,477.96
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	1,147.57	1,136.78
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	347.60	341.18
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	988.56	862.72
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	325.83	258.51
2132	Бусад урсгал шилжүүлэг	662.73	604.21
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	23,355.82	16,784.42
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	2,792.53	1,404.90
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	56,897.83	46,516.21
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	11,875.39	11,563.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	34,889.16	32,218.83
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	10,133.28	2,734.38
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	7,196.87
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	7,035.89

НЭГТГЭСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Төсвийн тохируулга
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	8,108.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	532.0
120	Нийтлэг татварын бус орлого	532.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,576.1
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,985.1
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,891.6
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	699.3
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,786.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,786.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	53.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	(5,404.5)
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	(405.9)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,810.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53.2
212	ТАТААС	733.4
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	733.4

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,999.4
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,891.6
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	107.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	5,322.0
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	5,171.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,171.8
2200	Дотоод эх үүсвэрээр	5,171.8
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(5,171.8)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	150.2
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	562.8
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	713.0

ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ
ХОЛБООТОЙ ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

д/д	Шалгагдагч байгууллагын нэр	Товч утга	Мөнгөн дүн	Гаргасан шийдэл
1	Аймгийн ЗДТГ	Тоног төхөөрөмж, тавилга эд хогшлын худалдан авалтыг хийхдээ тухайн бараа нь цахим дэлгүүрт байршсан эсэхэд судалгаа хийлгүй цахим дэлгүүрт бараа үйлчилгээгээ байршуулаагүй бусад этгээдээс худалдан авсан.	32,050.0	Албан шаардлага
2	Дэрэн сумын Орон нутгийн хөгжлийн сан	ОНХС-ийн хөрөнгийг шагнал урамшууллын зардалд зарцуулсан.	1,200.0	Төлбөрийн акт
3	Дэрэн сумын ЗДТГ	Цахим дэлгүүрт бараа үйлчилгээгээ байршуулаагүй бусад этгээдээс тоног төхөөрөмж худалдан авсан.	18,964.4	Албан шаардлага
4	Дэрэн сумын ЗДТГ	Бичиг хэргийг зардлаас сонин хэвлэлийн үнэ төлж төсвийг зориулалт бусаар хэмнэлтгүй зарцуулсан.	600.0	Төлбөрийн акт
5	Дэлгэрцогт сумын ЗДТГ	Цахим дэлгүүрт бараа үйлчилгээгээ байршуулаагүй бусад этгээдээс тоног төхөөрөмж худалдан авсан.	9,600.0	Албан шаардлага
6	Дэлгэрхангай сумын ЗДТГ	Хөдөлмөрийн хүндэт медаль, аймгийн хүндэт тэмдэг, аймгийн Засаг даргын жуух авсан албан хаагчдад мөнгөн шагналыг давхардуулан олгосон	500.0	Төлбөрийн акт
7	Говь-Угтаал сумын ЗДТГ	Тоног төхөөрөмжийн худалдан авалтыг хийхдээ тухайн бараа нь цахим дэлгүүрт байршсан эсэхэд судалгаа хийлгүй цахим дэлгүүрт бараа үйлчилгээгээ байршуулаагүй бусад этгээдээс тоног төхөөрөмж худалдан авсан.	29,280.0	Албан шаардлага
8	Адаацаг сумын ИТХ	Сумын ИТХ-ын албан хаагчийг гадаад туршлага судлах арга хэмжээнд хамруулж төсвөөс байр, хоол, унааны зардлыг олгосон.	980.0	Албан шаардлага
9	Өндөршил сумын ЗДТГ	Тоног төхөөрөмжийн худалдан авалтыг тус бараа нь цахим дэлгүүрт байршсан эсэхэд судалгаа хийлгүй цахим дэлгүүрт бараа үйлчилгээгээ байршуулаагүй бусад этгээдээс тоног төхөөрөмж худалдан авсан.	1,510.0	Албан шаардлага
10	Өлзийт сумын ЗДТГ	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж, сургалт зөвлөгөөнд оролцогчдод 900.0 мянган төгрөгийн гарын бэлэг, дурсгалын зүйл худалдан авч өгсөн.	900.0	Албан шаардлага
11	Аймгийн ИТХ	Албан хаагчид гадаад сургалтад хамрагдахаар БНСУ-ын Сөүл, БНХАУ-ын Хөх хотод агаарын тээврээр зорчихдоо үндэсний тээвэрлэгч компаниар үйлчлүүлээгүй нь төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн.	-	Албан шаардлага
12	Эрдэнэдалай сумын Орон нутгийн хөгжлийн сан	Хүүхэд хөгжлийн ордон тоног төхөөрөмж, суурилуулалт, дагалдах болон холболтын тоног төхөөрөмжийг нэмэлт гэрээ байгуулсан.	60,000.0	Зөвлөмж

13	Эрдэнэдалай сумын ЗДТГ	Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин төсвөөс бэлэг дурсгалын зүйл бэлтгэж, зарцуулсан	3,260.0	Төлбөрийн акт
14	Цагаандэлгэр сумын ЗДТГ	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал зардлаас албан хаагчдын хүүхдэд бэлэг өгч, төсвийг зориулалт бусаар зарцуулсан.	1,580.0	Албан шаардлага
	Нийт дүн		188,194.1	